

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчис ойл ХХК-ний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/93/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 51- 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК Захирал Ж.Бямбажав Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Компани ТӨҮГ, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Компани ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	14
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин .....	14
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	14
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	19
5.3 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	24
6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	24
6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	25
6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	27

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр Бага тосруу 3  
Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37 Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИС-ОЙЛ ХХК-ИЙН ЗАХИРЛЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ДАШХҮҮ ТАНАА

2026.03.16 № 06/650  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ес зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангуудад хийсэн аудитаар 15,435.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээр санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- "Агаарын хөлгийн түлш худалдах, худалдан авах гэрээ"-ний холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүйгээс үйл ажиллагаатай холбоотой шатахууны үйлчилгээ, хадгалалтын 1,182.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Ашигт малтмал газрын тосны газраас 36.7 сая төгрөг, 11 компаниас 9,785.2 сая төгрөгийн дизель түлш авч, нийт 9,821.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтад 7.3 сая төгрөг, хурал зохион байгуулахад 14.0 сая төгрөг, нийт 21.3 сая төгрөгийг холбогдох нотлох баримтгүйгээр зарцуулсан байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6, 15.2.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 23 дугаар зүйлийн 23.2-т заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2025 оны 116 тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтийн газрын 2025 оны 136 тогтоолын дагуу Зам, тээврийн яамтай хамтран Иргэний нисэхийн ерөнхий газраас “Чингис хаан” олон улсын нисэх буудлын “Шатахуун хангамжийн алба”-ыг, мөн Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тоог бууруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ыг тус тус Эрчис ойл ХХК-д нэгтгэсэн байна.

Ингэсэнээр Эрчис ойл ХХК-ийн агаарын хөлгийн шатахууны үнийг бууруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, харилцан хамааралгүй олон эх үүсвэрээс нөөцийг бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, онгоцын шатахуун хангалтыг тогтворжуулах зэргээр үйл ажиллагаа нь өргөжин тэлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 136 тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын Шатахуун хангамжийн албанаас 605 нэрийн 18,577.7 сая төгрөг хөрөнгө, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” -аас 408 нэрийн 20,897.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүд балансаас баланст шилжүүлэн авсан байна.

Эрчис ойл ХХК нь 10 худалдан авагчдад 23,054.3 сая төгрөгийн онгоцны түлшийг өртгөөр нь, 3 худалдан авагчдад 6,068.3 сая төгрөгийн онгоцны түлшийг өртгөөс нь 100.4 сая төгрөгөөр бага буюу 5,967.9 сая төгрөгөөр борлуулсан байна. Үүнээс шалтгаалан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлого төлөвлөснөөс 26.0 сая төгрөгөөр дутуу байна.

## **Бусад асуудал**

Агаарын хөлгийн түлшний хангамжийн олон талт эх үүсвэрийг бий болгох үүднээс гадаадын ханган нийлүүлэгч нартай хамтран ажиллаж байна. Тухайлбал 2025 онд Казакстаны Орал-Жан-Ойл компанитай гэрээ байгуулж, захиалга өгч баталгаажуулсан. Агаарын хөлгийн түлш худалдан авах, шинэ эх үүсвэрийг эрэлхийлэх үүднээс БНХАУ-ын үндэсний агаарын хөлгийн /CNAF/ төрийн өмчит компани, БНСУ-ын Үндэсний “Hyundai Oil” компани, ОХУ-ын Газпром” компаниудтай яриа хэлцлийг амжилттай хийсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгөн хөрөнгө	7,750,214,6 87.27	1,915,373,2 73.27
1.1.2	Дансны авлага	4,889,316,5 86.33	6,158,810,1 61.29
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	247,228,9 59.88	1,896,021,5 02.29
1.1.4	Бусад авлага	16,5 00.00	9,747,048,5 44.29
1.1.6	Бараа материал	21,760,301,7 89.76	24,098,339,0 59.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,338,298,5 02.93	9,821,877,0 71.13
<b>1.1.20</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>46,985,377,0 26.17</b>	<b>53,637,469,6 11.92</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	51,999,9 46.84	49,216,952,5 66.74
1.2.2	Биет бус хөрөнгө	17,851,5 15.18	1,236,677,4 32.29
1.1.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	70,144,4 53.46
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>69,851,4 62.02</b>	<b>50,523,774,4 52.50</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>47,055,228,4 88.19</b>	<b>104,161,244,064.36</b>
2.1.1.1	Дансны өглөг	0.00	9,836,986,0 28.10
2.1.1.3	Татварын өр	1,355,037,1 99.94	2,108,850,6 37.65
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	27,455,262,7 97.42	623,262,4 17.46
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	489,406,5 58.56	2,069,967,2 95.10
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>29,299,706,5 55.92</b>	<b>14,639,066,3 78.30</b>
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	12,499,5 73.91
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>12,499,5 73.91</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>29,299,706,5 55.92</b>	<b>14,651,565,9 52.21</b>
2.3.1	Өмч: а) төрийн	1,000,0 00.00	15,363,339,0 49.31
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	551,453,8 74.45
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	12,872,663,6 16.48	53,056,361,4 71.55
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	4,881,858,3 15.79	20,538,523,716.83
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17,755,521,9 32.27</b>	<b>89,509,678,1 12.14</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>47,055,228,4 88.19</b>	<b>104,161,244,064.36</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>215,915,059,447.34</b>	<b>228,068,706,973.38</b>
2	Борлуулалтын өртөг	193,126,901,041.09	207,609,038,580.97
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>22,788,158,406.25</b>	<b>20,459,668,392.41</b>
5	Хүүний орлого	69,194,483.31	258,076,854.81
8	Бусад орлого	-	2,786,780.99
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,931,274,433.10	12,237,451,559.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,700,191,734.78	3,365,052,691.69
12	Бусад зардал	-	19,144,230.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	(6,059,051,438.29)	1,627,434,954.04
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>9,166,835,283.39</b>	<b>6,726,318,500.84</b>
19	Орлогын татварын зардал	1,746,418,232.58	672,996,255.50
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>7,420,417,050.81</b>	<b>6,053,322,245.35</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>7,420,417,050.81</b>	<b>6,053,322,245.35</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>5,934,898,161.77</b>	<b>-</b>
	Бусад олз (гарз)	5,934,898,161.77	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>13,355,315,212.58</b>	<b>6,053,322,245.35</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>			<b>6,015,803,692.49</b>	<b>6,016,803,692.49</b>
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(2,619,464,266.34)	(2,619,464,266.34)
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	-	3,396,339,426.15	3,397,339,426.15
4	Тайлангийн үеийн цэвэр ашиг				1,485,518,889.64	1,485,518,889.64
5	Бусад дэлгэрэнгүй орлого			12,872,663,616.48		12,872,663,616.48
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдэл					-
<b>9</b>	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>	<b>-</b>	<b>12,872,663,616.48</b>	<b>4,881,858,315.79</b>	<b>17,755,521,932.27</b>
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				9,603,343,155.69	9,603,343,155.69
11	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	12,872,663,616.48	14,485,201,471.48	27,358,865,087.96
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг				6,053,322,245.35	6,053,322,245.35
13	Бусад дэлгэрэнгүй орлого		551,453,874.45	40,183,697,855.07		40,735,151,729.52
14	Өмчид гарсан өөрчлөлт	15,362,339,049.31				15,362,339,049.31
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдэл					-
<b>17</b>	<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>15,363,339,049.31</b>	<b>551,453,874.45</b>	<b>53,056,361,471.55</b>	<b>20,538,523,716.83</b>	<b>89,509,678,112.14</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	238,319,738,222.80	228,632,246,845.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	238,319,618,962.80	219,400,636,816.37
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	119,260.00	4,543,798.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	9,227,066,230.63
1.2	Мөнгөн зарлагын дүн	230,161,706,625.68	235,441,896,157.60
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	1,886,224,338.00	3,700,426,676.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	265,246,019.96	1,033,151,331.36
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	197,786,265,537.47	148,586,204,863.77
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	352,878,439.72	719,736,501.87
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,734,313,349.88	18,206,471,987.05
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,136,778,940.65	63,195,904,796.75
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8,158,031,597.12</b>	<b>(6,809,649,312.59)</b>
2.1	Мөнгөн орлогын дүн	76,836,365.97	2,338,257,588.46
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	2,082,112,250.96
2.1.5	Хүлээн авсан хүүний орлого	76,836,365.97	256,145,337.50
2.2	Мөнгөн зарлагын дүн	27,222,400.00	244,280,729.46
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	25,242,400.00	241,640,729.46
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,980,000.00	2,640,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>49,613,965.97</b>	<b>2,093,976,859.00</b>
3.1	Мөнгөн орлогын дүн	45,223,000,000.00	95,815,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	45,223,000,000.00	95,815,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	45,223,000,000.00	95,815,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	45,223,000,000.00	95,815,000,000.00
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>2,313,003,417.73</b>	<b>(1,575,518,951.33)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>10,520,648,980.82</b>	<b>(6,291,191,404.91)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>7,750,214,687.27</b>	<b>7,750,214,687.27</b>
<b>7</b>	<b>Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,750,214,687.27</b>	<b>1,915,373,273.27</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянгаан теергөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>									
	Борлуулалтын орлого	м.төг	215,984,253.9	253,826,747.1	228,068,706.9	12,084,453.0	105.6	(25,758,040.2)	89.9
1	Бусад орлого	м.төг	215,915,059.4	253,826,747.1	227,807,843.4	11,892,784.0	105.5	(26,018,903.7)	89.7
	Хүүний орлого	м.төг	69,194.5		2,786.7	(66,407.8)	4.0	2,786.7	
					258,076.8	258,076.8		258,076.8	
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>215,984,253.9</b>	<b>253,826,747.1</b>	<b>228,068,706.9</b>	<b>12,084,453.0</b>	<b>105.6</b>	<b>(25,758,040.2)</b>	<b>89.9</b>
	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>206,817,418.6</b>	<b>259,462,627.1</b>	<b>221,342,388.4</b>	<b>14,524,969.8</b>	<b>107.0</b>	<b>(38,120,238.7)</b>	<b>85.3</b>
3	Үүнээс: Бараа материалын өртөг	м.төг	199,185,952.5	235,726,140.0	205,739,884.1	6,553,931.6	103.3	(29,986,255.9)	87.3
	Ерөнхий ба удирдлагын зардал		1,700,191.7	9,778,062.1	3,365,052.7				
	Борлуулалт маркетингийн зардал		5,931,274.4	13,958,425.0	12,237,451.6				
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>9,166,835.3</b>	<b>(5,635,880.0)</b>	<b>6,726,318.5</b>	<b>(2,440,516.8)</b>	<b>73.4</b>	<b>12,362,198.5</b>	<b>(119.3)</b>
	Орлогын татварын зардал	м.төг		-	672,996.,3				
5	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>м.төг</b>	<b>-</b>	<b>(5,635,880.0 )</b>	<b>6,053,322.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>20,761,224.1</b>	<b>25,783,515.3</b>	<b>25,969,880.5</b>	<b>5,208,656.4</b>	<b>125.1</b>	<b>186,365.2</b>	<b>100.7</b>
6	а/ Орлогын татварт	м.төг	1,551,651.9	-	672,996.3	(878,655.6)	43.4	672,996.3	
	б/ НӨТ	м.төг	18,841,684.6	24,144,437.9	23,722,026.5	4,880,341.9	125.9	(422,411.4)	98.3
	в/ НДШ	м.төг	265,246.0	1,224,540.0	1,032,328.6	767,082.6	389.2	(192,211.4)	84.3
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	102,641.6	414,537.4	261,596.8	158,955.2	254.9	(152,940.6)	63.1
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	20.0	83.0	115.0	95.0	575.0	32.0	138.6
9	Нийт цалингийн сан	м.төг	1,155,981.5	4,051,632.6	3,133,251.3	1,977,269.8	271.0	(918,381.3)	77.3
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,627.0	3,826.9	2,270.4	(1,356.6)	62.6	(1,556.5)	59.3
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.0	1.0	0.0	100.1	(0.0)	95.1
12	Хөрөнгө оруулалт	м.төг	24,747.6	6,051,250.0		(24,747.6)	-	(6,051,250.0)	-
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>17,474,860.5</b>	<b>3,864,919.0</b>	<b>11,643,070.0</b>	<b>(5,831,790.5)</b>	<b>66.6</b>	<b>7,778,151.0</b>	<b>301.3</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>29,299,706.6</b>	<b>3,052,920.6</b>	<b>14,639,066.4</b>	<b>(14,660,640.2)</b>	<b>50.0</b>	<b>11,586,145.8</b>	<b>479.5</b>
	Богино хугацаат ер төлбөр	м.төг	29,299,706.6	-	14,639,066.4	(14,660,640.2)	50.0	14,639,066.4	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Эрчис ойл ХХК нь эрхэм зорилгоо "Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын шатахуун хангамж"-тай холбоотой үйл ажиллагааг эрхлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Эрчис ойл ХХК нь газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тогтворжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолоор "Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцэн баталсан бөгөөд "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ нисэх онгоцны буудлын агаарын хөлгийн түлшний хангамжийн үйл ажиллагаа эрхлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/81 тоот тушаалаар Эрчис ойл ХХК 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

Эрчис ойл ХХК нь дараах үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн эрхтэй байна. Үүнд:

- Худалдааны зуучлал
- Хатуу, шингэн, хийн түлш, түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний бөөний худалдаа
- Бүх төрлийн шатахууны импортын худалдаа
- Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Компани ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Эрчис ойл ХХК нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Үндсэн хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд, Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжууд болон Олон Улсын гэрээ хэлэлцээр зэрэгт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын хууль “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай”,
- Засгийн газрын 2025 оны “Эрчист Монгол” ХХК-ий харьяа компаниудын жагсаалт батлах 04 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2025 оны “Агаарын хөлгийн түлшний нөөц бүрдүүлэх тухай” 34 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2025 оны 116 дугаар тогтоол болон “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоол,
- Сангийн сайдын 2025 оны “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах” тухай А/103, 104, 105, 106 дугаар тушаалууд

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзсэн.

Компани нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, толгой компани болох

Эрчис Монгол ХХК-ийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хяналтын үүрэг хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчис ойл ХХК-ийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 29-ны А/25 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрчис ойл ХХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,106.0 сая төгрөгөөр буюу 121.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	7,750,214.7	1,915,373.3	(5,834,841.4)
Авлага	5,136,562.0	17,801,880.2	12,665,318.2
Урьдчилгаа	12,338,298.5	9,821,877.1	(2,516,421.4)
Бараа материал	21,760,301.8	24,098,339.1	2,338,037.3
Үндсэн хөрөнгө	69,851.5	50,523,774.5	50,453,923.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>47,055,228.5</b>	<b>104,161,244.1</b>	<b>57,106,015.6</b>
Өр төлбөр	29,299,706.6	14,651,566.0	(14,648,140.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,755,521.9	89,509,678.1	71,754,156.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>47,055,228.5</b>	<b>104,161,244.1</b>	<b>57,106,015.6</b>

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, урт бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан ашиг, алдагдлын дансууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,915.4 сая төгрөг болж, өмнөх оноос 5,834.8 сая төгрөгөөр буурсан нь орон тоо нэмэгдсэнээс цалин хөлс 1,814.2 сая төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл 767.9 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагуудад 2,885.8 сая төгрөг, Хаан банкнаас авсан зээлийн хүүд төлсөн мөнгө 719.7 сая төгрөгөөр тус тус зардал өссөнөөс шалтгаалсан байна.
- Авлагын үлдэгдэл оны эцэст 17,801.8 сая төгрөг болж, 246.6 хувиар өссөн байна. Үүнд: Авлага дансны үлдэгдэлд “Монголын Иргэний Агаарын Тээвэр” ТӨХК-аас 2,215.4 сая төгрөг, “Аэро Монголиа” ХХК-аас 1,323.0 сая төгрөг, “Uniken International” ХХК -аас 429.3 сая төгрөг, “Хүннү Эйр” ХХК -аас 223.8 сая төгрөг, “Крас авиа “ХХК -аас 61.5 сая төгрөг, “Ир Аэро” ХХК-аас 10.9 сая төгрөг, “Геологи судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ -аас 10.3 сая төгрөг, “Монголиа Авиашин Фүел” ХХК -аас 10.7 сая төгрөг, “ИНҮТ” ХХК-аас 640.4 сая төгрөг, “Мэргэвэн” ХХК-аас 1,182.2 сая төгрөг, “Альфа авиашин фүел” ХХК -аас 7,409.6 сая төгрөгийн авлагууд байна.Энэ

нь худалдан авагч компаниудаас авах авлага 13,534.3 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

- Бараа материал дансны үлдэгдэл 24,098.3 сая төгрөг болж, өмнөх оноос 2,338.0 сая төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 499,290.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 496,952.7 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Үүнд: Бэлэн бүтээгдэхүүн /Онгоцны түлш/ 496,295.1 сая төгрөг буюу нийт бараа материалын 99.0 хувийг эзэлж байна.  
Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 136 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын 306.0 сая төгрөгийн бараа материал орлогод авсан байна.
- Урьдчилж төлсөн тооцоо дансанд “Грийн Химистри” ХХК-ийн 7.6 сая төгрөг, “Дэлгэрэх цаст цамбагарав” ХХК-ийн 14.6 сая төгрөг, “Чуангс-Эдэлвайз” ХХК -ийн 15.1 сая төгрөг, урьдчилж төлсөн зардал дансанд “УБТЗ” ХНН-ийн 29.5 сая төгрөг, “Роснефть Аэро” ХХК -ийн 431.9 сая төгрөг, “Альфа авиашин фүел” ХХК -ийн 9,323.1 сая төгрөгийн зардлууд үлдэгдэлтэй байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 50,523.7 сая төгрөг болж, өмнөх оноос 50,453.9 сая төгрөгөөр өссөн нь Иргэний нисэхийн ерөнхий газрын Шатахуун хангалтын алба болон Дорноговь аймгийн Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж”-ын үндсэн хөрөнгүүд нэмэгдэн балансаас баланст шилжүүлэн авсантай холбоотой байна.  
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 136 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 186.9 сая төгрөгийн 1 газар, 36,043.3 сая төгрөгийн 21 барилга байгууламж, 13,156.4 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, 25.4 сая төгрөгийн хэвлэх хувилах төхөөрөмж, 5,053.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 140.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 194.4 сая төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл, 7.4 сая төгрөгийн эрх, нийт 54,807.9 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч, мөн Дорноговь аймгийн Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж”-ийн 408 нэрийн 13,464.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 504 дүгээр тогтоолоор балансаас баланст шилжүүлэн авсан байна.
- Биет бус хөрөнгө 1,218.8 сая төгрөгөөр нэмэгдэж оны эцсийн байдлаар 1,236.6 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Биет бус хөрөнгө нь ‘Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж’ ТӨҮГ-ын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 369.2 сая төгрөгийн Скада програм /ачилтын автоматжуулалтын/, 576.3 сая төгрөгийн агуулахын автоматжуулалтын программ, 560.6 сая төгрөгийн газар эзэмших эрх, 143.2 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Богино хугацаат зээл дансны үлдэгдэл нийт дүнгээр 14,651.5 сая төгрөг болж, 14,648.1 сая төгрөгөөр буурсан нь гэрээт худалдан авагч харилцагчид гэрээний дагуу худалдан авах барааны төлбөрөө төлсөнтэй холбоотой байна.
- Урьдчилж орсон бусад орлого дансны оны эхний үлдэгдэл 27,378.2 сая төгрөг байсан бол 27,311.6 сая төгрөгөөр буурч оны эцэст 66.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэлд Ашигт малтмал газрын тосны газрын түлшний болон түлшний төлбөрт гэж шилжүүлсэн 9,821.9 сая төгрөгийн, Тэнгэрийн улаач шинэ ХХК-ийн 65.6 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Биет бус хөрөнгийн дансанд 9.4 сая төгрөгийн санхүүгийн программ болон Камер холбох лиценз, стандарт лиценз эрх 7.4 сая төгрөг нийт 16.8 сая төгрөг биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. Тайлангийн хугацаанд “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 369.2 сая төгрөгийн Скада программ, 576.3 сая төгрөгийн агуулахын автоматжуулалтын программ тус тус нэмэгдсэн байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрчис ойл ХХК нь үйл ажиллагааны болон зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 14 дүгээр тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 253,826.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 259,462.6 сая төгрөгөөр, 5,635.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,051.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

#### **3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 228,068.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 221,342.4 сая төгрөгийн зардал гарган, 6,726.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 228,068.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 10.1 хувиар тасарсан нь агаарын хөлгийн түлшийг зах зээлийн боломжит доод үнээр агаарын тээвэрлэгч нарт нийлүүлж байгаатай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 221,342.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 38,120.2 сая төгрөгөөр буюу 14.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь ерөнхий ба удирдлагын зардлыг 6,413.0 сая төгрөгөөр, бараа материалын өртгийг 29,986.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 6,053.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 12,362.2 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогын төлөвлөгөөг 89.9 хувьтай биелүүлж, нийт зардал 85.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

##### *1.Төвийн орон тооны цомхотголын талаар:*

Эрчис ойл ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 17 дугаар тогтоолоор компанийн бүтэц, орон тоог 23 ажилтан баталсан байна. ТУЗ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 15 дугаар тогтоолоор шатахуун хангамж, байгууламж, төслийн нэгжийн болон Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн бүтэц орон тооны хязгаарыг 125 ажилтантай байхаар баталсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 08-ний өдрийн 18 дугаар тогтоолоор бүтэц орон тоог шинэчлэн баталж орон тооны хязгаарыг 123 ажилтантай баталж гүйцэтгэлээр 95 ажилтан ажилласан байна.

##### *2.Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:*

Эрчис ойл” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн А/39 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны зардлыг 20,000.00 төгрөг, унааны зардалыг 2,000.00 төгрөгөөр шинэчлэн тогтоож тайлант хугацаанд 436.6 сая төгрөгийн төсөв баталснаас 272.7 сая төгрөгийн унаа, хоолны зардалд зарцуулж 163.9 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна.

##### *3.Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн:*

Тус компани нь гадаад томилолтод 125.6 сая төгрөг батлагдсанаас 25.2 сая төгрөг зарцуулсан байна. Тухайлбал: Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайдын удирдамжаар тус яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, тус компанийн Төлөөлөн удирдах

зөвлөлийн дарга Ц.Батцайз нь гүйцэтгэх захирлын тушаалаар Канад улсын Торонто хотод "PDAC-2025" олон улсын уул уурхайн чуулга уулзалтад оролцох гадаад албан томилолтын зардалд 13.8 сая төгрөг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот удирдамжийн дагуу ТУЗ-ийн гишүүн Ч.Хишигдалай компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/12 тушаалаар ОХУ-ын “Роснефть” компанитай онгоцны түлшний нийлүүлэлт хийх уулзалтын оролцох гадаад томилолтын зардалд 11.4 сая төгрөгийг тус тус зарцуулан олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалтад оролцон үр дүнг тайлагнаж ажилласан байна.

#### 4.Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн

“Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, байгаль орчин эрдэм шинжилгээ сургалт судалгааны төв”-д 14.7 сая төгрөг, Боловсролын хөгжлийн хүрээлэнд 20.0 сая төгрөг, “Мон-Аэртур” ХХК-д 21.3 сая төгрөг, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд 0.3 сая төгрөг, нийт 56.4 сая төгрөгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалт, хурал зохион байгуулахад мөн ажилчдын ажлын байрны сургалтад зарцуулсан байна.

#### **3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5,860.4 сая төгрөгийн 9 нэр төрлийн бараа материал худалдан авахаар төлөвлөж, баталсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендерт 3,991.4 сая төгрөг, харьцуулалтын аргаар 171.6 сая төгрөг, 68 нэгжийн 694.8 саян төгрөгийн шууд худалдан авалт тус тус хийж 1,002.5 сая худалдан авалт хийгээгүй хойшлогдсон байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрчис ойл ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрчис ойл ХХК-ийн түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай аудит” ХХК-ийн ахлах аудитор Н.Тэмүүжин, аудитор З.Мандах нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Я.Марал-Эрдэнэ, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/144 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 208,563.8 сая төгрөгийн 0.5 хувиар тооцож, 1,042.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог шинэчлэн, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 221,342.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 38,120.2 сая төгрөг буюу 15 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Тухайлбал: үндсэн ба нэмэгдэл цалингийн болон хоол унааны 523.6 сая төгрөг, сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал 200.9 сая төгрөг, бараа материал өртөг зардлыг 29,986.3 сая төгрөгөөр тус тус зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 71,739.6 сая төгрөгийн зөрчилд арилгах албан шаардлага хүргүүлсэн

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 71,739.6 сая төгрөгийн 1210 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .**

Төрийн хэмнэлтийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт нь холбогдох хууль, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар тус компанийн 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулан мөнгөн хөрөнгийн дансттай холбоотой горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 26.3 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж, асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажууллаа. Жилийн эцсийн аудитаар залруулга хийсэн эсэхийг дахин нягталж, аудитын тайланд залруулгаар тусгалаа.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжилтийг 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 07/1067 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт биелэлтийн тайлан, нотлох баримтын хамт хүргүүлсэн байна.

Өмөнх аудитаар өгсөн 1 зөвлөмж 80.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	1	-	1	-	80.0
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>80.0</b>

Өмнөх аудитаар өгсөн хэрэгжээгүй зөвлөмжийг хэрхэн шийдвэрлэсэн асуудалд албан шаардлага хүргүүлсэн.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал:

- Компанийн борлуулалт, өртөг зардлын тарифт гүйцэтгэлийн хяналт хэрэгжүүлэх
- Тушаал шийдвэр боловсруулалтын байдалд дотоод хяналт хэрэгжүүлсэн ажлыг үнэлж дүгнэх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 26.3 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Мөнгөн хөрөнгийн данснаас вагон буцаалтын төлбөрийн 26.3 сая төгрөгийг тооцоог үүсгээгүй шууд "Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг" дансанд бүртгэсэн байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар 15.2-т *"нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна"* гэж заасны дагуу санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 15,435.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 1.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 107.5 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 15,325.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 15,435.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

#### Илрүүлэлт 1:

Олон Улсын нисэх буудлын хангамжийн байгууламжийг нэгтгэх уулзалтад оролцогчдод 1.6 сая төгрөгт бараа худалдан авч зочид төлөөлөгчдийн гарын бэлэгт зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"үр ашигтай байх;"*, 12 дугаар зүйлийн 12.1-т *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.*

#### Шийдвэрлэсэн нь:

Зочид төлөөлөгчдөд гарын бэлэгт зарцуулсан 1.6 сая төгрөгийг төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

#### Илрүүлэлт 2:

Байгууллагын мөнгөн хөрөнгийн нярвын 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийн тооцоог бодоход 0.2 сая төгрөг дутагдсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл, 4<sup>1</sup>*"үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д *"үнэн зөв байх"*, 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"* гэсэн заалтууд, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Дутагдсан бэлэн мөнгө 0.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

### Илрүүлэлт 1:

Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс шинэ жилийн хүүхдийн бэлэгт бараа худалдан авсны төлбөрт нийт 17.3 сая төгрөгийг шилжүүлж, баримтын бүрдэл дутуу, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"үр ашигтай байх;"*, 12 дугаар зүйлийн 12.1-д *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:"*, 12.1.4-т *"хуулиар зөвшөөрөөгүй бусад"*, 15.1.5-д *"төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;"* гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс хүүхдийн бэлэг бэлтгэн үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### Илрүүлэлт 2:

Тайлант онд албан хэрэгцээнд зориулан 2.8 сая төгрөгийн кофе, цайг хүргэлтийн үйлчилгээгээр захиалан худалдан авч үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно"*, 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"*, Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 *"үр ашигтай байх;"* гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Кофе цайг хүргэлтийн үйлчилгээгээр захиалан худалдан авч үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### Илрүүлэлт 3:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын удирдамж, гүйцэтгэх захирлын тушаалаар ТУЗ-ийн даргад (АҮЭБЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга) Канад улсын Торонто хотод болсон "PDAC-2025" олон улсын уул уурхайн чуулга уулзалтад оролцож, гадаад албан томилолтын зардалд 13.8 сая төгрөгийг зориулалт зөрчин зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ."*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"*, Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолын 2.2.-д заасан *"төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Гадаад албан томилолтын зардалд зориулалт зөрчин зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### Илрүүлэлт 4:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 14 дүгээр тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж компьютер, техник хэрэгсэл худалдан авах 35.3 сая төгрөгийн төсвийг 41.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Тендерт "Монтех

Дистрибьюшин” ХХК шалгарч 2025 оны 03 дугаар сарын 18-нд гэрээ байгуулан 33.2 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл нийлүүлсэн. Мөн 2025 оны 08 дугаар сарын 15-нд “Голденхоул” ХХК-тай гэрээ байгуулан 32.8 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл авч, батлагдсан төлөвлөгөөнөөс 25.0 сая төгрөгийн илүү худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.9-д “аж ахуйн нээж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 “үр ашигтай байх;” Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.” Гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан төсвийг хэтрүүлэн илүү худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 5:**

Ажлын байрны нөхцөл муу, түрээсийн зардал өндөр зэргээс шалтгаалж ажлын байрыг 3 удаа сольж, нүүлгэлтийн зардалд “Монгол иса нүүлгэлт” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 04-нд 4.0 сая төгрөг, 2025 оны 09 дүгээр сарын 04-нд 5.0 сая төгрөг, Нуга этүгэн ХХК -нд 2025 оны 12 дугаар сарын 02-нд 5.0 сая төгрөг, нийт 14.0 сая төгрөг шилжүүлж, үр ашиггүй зардал гарсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэсэн заалттай, санхүүгийн батламж мэдэгдлийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 6:**

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 13 дугаар тогтоолоор “Петрожамп” ХХК-аас авах 4.8 сая төгрөгийн авлагыг хүчингүй болгож бүртгэлээс хассан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;” заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Авлагыг хүчингүй болгож бүртгэлээс хассан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 7:**

Тайланд онд Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтад 7.3 сая төгрөг, хурал зохион байгуулахад зориулан 14.0 сая төгрөг, нийт 21.3 сая төгрөгийг “Мон-Аэртур” ХХК-д шилжүүлэн нотлох, дэмжих баримтгүй үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 “үр ашигтай байх;”, 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно.” 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалт, хурал зохион байгуулахад үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 8:**

"Чингис хаан" Олон Улсын Нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг удирдах хамтарсан компани байгуулах ажлын хэсгийн анхдугаар уулзалтад “Велосити инфинит” ХХК, “Шангила Улаанбаатар”, “Наадам ресторан”-д заалны түрээс болон хоолны үйлчилгээний төлбөрт 7.7 сая төгрөг, “Гас” ХХК-д зочид төлөөлөгчдөд тээврийн хэрэгслийн үйлчилгээнд 0.4 сая төгрөг, нийт 8.1 сая төгрөг анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэлийн тайлангүй, үр ашиггүй зарцуулсан байна.

*Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 “үр ашигтай байх;”, 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно.”, 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.*

**Шийдвэрлэсэн нь:**

Хамтарсан компани байгуулах ажлын хэсгийн анхдугаар уулзалтад зориулж заалны түрээс болон хоол, тээврийн үйлчилгээний төлбөрийг аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэн үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 188 нэр төрлийн нийт 67.5 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

## 2. Авлагын данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

“Альфа аурора авиэшн” ХХК-аас авах 143.3 сая төгрөг, “Изинис эйрвейз” ХХК-аас авах 383.1 сая төгрөгийн өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэнтэй нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах

### Илрүүлэлт:

Ус илрүүлэгч худалдан авахаар Грийн Химистри ХХК-д 16.3 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж 7.6 сая төгрөг, “Автомашины утаа бууруулагч” -ыг худалдан авахаар Дэлгэрэх цаст цамбагарав ХХК-д 14.6 сая төгрөг шилжүүлж, нийт 22.2 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй, авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх,” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг хүлээн авч, авлагыг барагдуулах арга хэмжээ авах

### Илрүүлэлт:

Агаарын хөлгийн түлш худалдах, худалдан авах гэрээний холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүйгээс “МИАТ” ТӨХК -аас 2,215.4 сая төгрөг, “Аэро монголиа” ХХК -аас 1,323.0 сая төгрөг, “Хүннү эйр” ХХК-аас 224.5 сая төгрөг, “Геологи судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ-аас 10.3 сая төгрөг, “Мэргэван” ХХК-аас сумалгаа хадгалалтын 1,182.2 сая төгрөгийн үйл ажиллагаатай холбоотой авлагын үлдэгдэл байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх,” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Агаарын хөлгийн түлш худалдах, худалдан авах гэрээний заалтыг мөрдөн ажиллаж гэрээг дүгнэн, авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

## 3. Өглөгийн данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Ашигт малтмал газрын тосны газраас 36.8 сая төгрөг, 11 компаниас 9,785.2 сая төгрөгийн дизель түлш авч, нийт 9,822.0 сая төгрөгийн дансны өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх,” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өглөгийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах

**5. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас “Газрын мэдээллийн лавлагаа” авч санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад улсын кадастрын нэгдсэн системд бүртгэлтэй 3 газрын талбайн хэмжээг данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.

*Энэ нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйл, “Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам”-ын 34.5-д “Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон газрын нэгж талбарын дугаар, хэмжээ, байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна” гэж тус тус заасантай нийцээгүй;*

Өгсөн зөвлөмж:

Холбогдох газрын албатай газрын талбайн хэмжээг баталгаажуулж бүртгэлд үнэн зөв тусгах арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн хөрөнгийн данснаас вагон буцаалтын төлбөрийн 26,291.5 мянган төгрөгийг тооцоог үүсгээгүй шууд "Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг" дансанд бүртгэсэн байна.	1	26,291.5			1	26,291.5	1	26,291.5				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>26,291.5</b>	-	-	<b>1</b>	<b>26,291.5</b>	<b>1</b>	<b>26,291.5</b>	-	-	-	-

**6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Олон Улсын нисэх буудлын хангамжийн байгууламжийг нэгтгэх уулзалтад оролцогчдод 1.6 сая төгрөгт бараа худалдан авч зочид төлөөлөгчдийн гарын бэлэгт зарцуулсан байна.	1	1,608.0	1	1,608.0				
2	Байгууллагын мөнгөн хөрөнгийн нярвын 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийн тооцоог бодоход 0.2 сая төгрөг дутагдсан.	1	185.6	1	185.6				
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 14 дүгээр тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж компьютер, техник хэрэгсэл худалдан авах 35.3 сая төгрөгийн төсвийг 41.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Тендерт “Монтех Дистрибьюшин” ХХК шалгарч 2025 оны 03 дугаар сарын 18-нд гэрээ байгуулан 33.2 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл нийлүүлсэн. Мөн 2025 оны 08 дугаар сарын 15-нд “Голденхоул” ХХК-тай гэрээ байгуулан 32.8 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл авч, батлагдсан төлөвлөгөөнөөс 25.0 сая төгрөгийн илүү худалдан авалт хийсэн байна.	1	25,048.7			1	25,048.7		
4	Ажлын байрны нөхцөл муу, түрээсийн зардал өндөр зэргээс шалтгаалж ажлын байрыг 3 удаа сольж, нүүлгэлтийн зардалд “Монгол иса нүүлгэлт” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 04-нд 4.0 сая төгрөг, 2025 оны 09 дүгээр сарын 04-нд 5.0 сая төгрөг, Нуга этүгэн ХХК -нд 2025 оны 12 дугаар сарын 02-нд 5.0 сая төгрөг, нийт 14.0 сая төгрөг шилжүүлж, үр ашиггүй зардал гарсан байна.	1	14,020.0			1	14,020.0		
5	Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 13 дугаар тогтоолоор “Петрожамп” ХХК-аас авах 4.8 сая төгрөгийн авлагыг хүчингүй болгож бүртгэлээс хассан байна.	1	4,885.8			1	4,885.8		
6	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын удирдамж, гүйцэтгэх захирлын тушаалаар ТУЗ-ийн даргад (АҮЭБЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга) Канад улсын Торонто хотод болсон "PDAC-2025" олон улсын уул уурхайн чуулга уулзалтад оролцож, гадаад албан томилолтын зардалд 13.8 сая төгрөгийг зориулалт зөрчин зарцуулсан байна.	1	13,865.3			1	13,865.3		
7	Тайланд онд Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтад 7.3 сая төгрөг, хурал зохион байгуулахад зориулан 14.0 сая төгрөг, нийт	1	21,333.3			1	21,333.3		

“Эрчис Ойл” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	21.3 сая төгрөгийг “Мон-Аэртур” ХХК-д шилжүүлэн нотлох, дэмжих баримтгүй үр ашиггүй зарцуулсан байна.							
8	“Чингис хаан” Олон Улсын Нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг удирдах хамтарсан компани байгуулах ажлын хэсгийн анхдугаар уулзалтад “Велосити инфинит” ХХК, “Шангрила Улаанбаатар”, “Наадам ресторан”-д заалны түрээс болон хоолны үйлчилгээний төлбөрт 7.7 сая төгрөг, “Гас” ХХК-д зочид төлөөлөгчдөд тээврийн хэрэгслийн үйлчилгээнд 0.4 сая төгрөг, нийт 8.1 сая төгрөг анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэлийн тайлангүй, үр ашиггүй зарцуулсан байна.	1	8,238.2			1	8,238.2	
9	Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс шинэ жилийн хүүхдийн бэлэгт бараа худалдан авсны төлбөрт нийт 17.3 сая төгрөгийг шилжүүлж, баримтын бүрдэл дутуу, үрэлгэн зарцуулсан байна.	1	17,299.8			1	17,299.8	
10	Тайлант онд албан хэрэгцээнд зориулан 2.8 сая төгрөгийн кофе, цайг хүргэлтийн үйлчилгээгээр захиалан худалдан авч үрэлгэн зарцуулсан байна.	1	2,861.8			1	2,861.8	
11	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 188 нэр төрлийн нийт 67,598.2 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-				1	-
12	Alpha aurora aviation ХХК-аас авах 143,319.3 мянган төгрөг, Изинис эйрвейз ХХК-аас авах 383,087.1 мянган төгрөгийн өмнөх оны үлдэгдлийг барагдуулаагүй байна.	1	526,406.4				1	526,406.4
13	Ус илрүүлэгч худалдан авахаар "Грийн Химистри ХХК-д 16,278.9 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж 7,632.9 мянган төгрөг, "Автомашины утаа бууруулагч" -ыг худалдан авахаар Дэлгэрэх цаст цамбагарав ХХК-д 14,600.0 мянган төгрөг шилжүүлж, нийт 22,223.9 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй, авлагыг барагдуулаагүй байна.	1	22,223.9				1	22,223.9
14	Агаарын хөлгийн түлш худалдах, худалдан авах гэрээний заалтыг мөрдөж ажиллаагүйгээс МИАТ ТӨХК -аас 2,215,371.0 мянган төгрөг, Аэро монголиа ХХК -аас 1,323,034.5 мянган төгрөг, Хүннү эйр ХХК -аас 224,470.5 мянган төгрөг, Геологи судалгаа шинжилгээний төв ТӨҮГ-аас 10,290.4 мянган төгрөг, Мэргэван ХХК-аас сумалгаа хадгалалтын 1,182,189.6 мянган төгрөгийн үйл ажиллагаатай холбоотой авлагын үлдэгдэлтэй байна.	1	4,955,356.1				1	4,955,356.1
15	Ашигт малтмал газрын тосны газраас 36,800.0 мянган төгрөг, 11 компаниас 9,785,193.0 мянган төгрөгийн дизель түлш авч, нийт 9,821,992.9 мянган төгрөгийн дансны өглөгийн үлдэгдэлтэй байна.	1	9,821,992.9				1	9,821,992.9

16	Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан,үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад улсын кадастрын нэгдсэн системд бүртгэлтэй 3 газрын талбайн хэмжээг данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>		<b>16</b>	<b>15,435,325.9</b>	<b>2</b>	<b>1,793.6</b>	<b>8</b>	<b>107,553.0</b>	<b>6</b>	<b>15,325,979.4</b>

### 6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
1	Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 71,739,605.0 мянган төгрөгийн 1210 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан.	1	71,739,695.0			1	71,739,695.0		
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>71,739,695.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>71,739,695.0</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар

150/А0150053

Улаанбаатар хот

С/БТ-0006/93/НА-СТЭ-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон Улсын нисэх буудлын хангамжийн байгууламжийг нэгтгэх уулзалтад оролцогчдод 1,608.000.00 /нэг сая зургаан зуун найман мянган/ төгрөгийн гарын бэлэг авч зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх"; 12 дугаар зүйлийн 12.1-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад"; 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Уулзалтын ажлын хэсгийн оролцогчдод гарын бэлэгт 1,608.000.00 /нэг сая зургаан зуун найман мянган/ төгрөгийг Эрчис ойл ХХК-ийн Захиргаа, хүний нөөцийн албаны дарга С.Буянхишиг, ерөнхий менежер З.Цэлмэг, Санхүү албаны дарга Х.Эрдэнэбилэг, ерөнхий нягтлан бодогч Д.Мядагбадам нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гиргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 151/2015-0053

Улаанбаатар хот

СМГ-2026/83/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын мөнгөн хөрөнгийн нярвын 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийн тооцоог бодоход 185.600.48 /нэг зуун наян таван мянга зургаан зуун төгрөг дөчин найман мөнгө/ төгрөг дутагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл, 4/ "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шилдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтууд. "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5. "бүртгэл, тооцоог зөрүүтэй тосцоолсноос үр дагавар үүссэн" гэсэн заалтыг үндэслэн; **ТОГТООХ нь:**

1. Эрчис ойл ХХК-ийн нярав Т.Энхбулгангаар дутагдсан 185.600.48 /нэг зуун наян таван мянга зургаан зуун төгрөг дөчин найман мөнгө/ төгрөгийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыгийг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 649/АО150053

Улаанбаатар хот

САГ-2026/93/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс шинэ жилийн хүүхдийн бэлэгт бараа худалдан авсны төлбөрт нийт 17,299,855.00 /арван долоон сая хоёр зуун ерэн есөн мянга найман зуун тавин таван/ төгрөгийг шилжүүлж, баримтын бүрдэл дутуу, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс хүүхдийн бэлэг бэлтгэн үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЯБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

НАРАНЧИМЭГ  
ДЭНХДАЛАЙ  
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 650/А0150053  
САН-2026/53/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтад 7,333,000.00 /долоон сая гурван зуун гучин гурван мянган/ төгрөг, хурал зохион байгуулахад зориулан 14,000,000.00 /арван дөрвөн сая/ төгрөг, нийт 21,333,000.00 /хорин нэгэн сая гурван зуун гучин гурван мянган/ төгрөгийг Мон-Аэртур ХХК-д шилжүүлэн нотлох, дэмжих баримтгүй үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх.", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно." 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1.нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; 4.2.1.11"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалт, хурал зохион байгуулахад үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 651/20150053

Улаансаатар хот

САГ-2026/33) Н.А-СТЭ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 13 дугаар тогтоолоор Петрожамп ХХК-аас авах 4,885,816.00 /Дөрвөн сая найман зуун наян таван мянга найман зуун арван зургаан/ төгрөгийн авлагыг хүчингүй болгож бүртгэлээс хассан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалттай нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохиох есоор хөтөлж, баталгаажуулагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг хүчингүй болгож бүртгэлээс хассан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 652/20150053

Улаанбаатар хот

С.ТӨГ - 2006/83/НА - СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын удирдамж, гүйцэтгэх захирлын тушаалаар Төлөөлөн Удирдах 3-өвлөлийн даргад (АҮЭБЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга) Канад улсын Торонто хотод болсон "PDAC-2025" олон улсын уул уурхайн чуулга уулзалтад оролцож гадаад албан томилолтын зардалд 13,865,254.00 /арван гурван сая найман зуун жаран таван мянга хоёр зуун тавин дөрвөн/ төгрөгийг зориулалт зөрчин зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолын 2.2.-д заасан "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11" хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байсал" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Гадаад албан томилолтын зардалд зориулалт зөрчин зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 653/АД/50053

/гаансаатар хот

САГ-2026/53/НА-СТА-ТГА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын байрны нөхцөл муу, түрээсийн зардал өндөр зэргээс шалтгаалж ажлын байрыг 3 удаа сольж нүүлгэлтийн зардалд Монгол иса нүүлгэлт ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 04-нд 4,000,000.00 /дөрвөн сая/ төгрөг, 2025 оны 09 дүгээр сарын 04-нд 4,800,000.00 /дөрвөн сая найман зуун мянган/ төгрөг, Нуга этүгэн ХХК -нд 2025 оны 12 дугаар сарын 02-нд 5,220,000.00 /таван сая хоёр зуун хорин мянган/ төгрөг, нийт 14,020,000.00 /Арван дөрвөн сая хорин мянган/ төгрөг шилжүүлж, үр ашиггүй зардал гарсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай, санхүүгийн батламж мэдэгдлийн нийцсэнгүй зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;" гэсэн заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 654/А0150053

Улаанбаатар хот

САТ-2026/33/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 14 дүгээр тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж компьютер, техник хэрэгсэл худалдан авах 35.250.000.00 /гучин таван сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийн төсвийг 41.000.000.00 /дөчин нэгэн сая/ төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Тендерт Монтех Дистрибьюшин ХХК шалгарч 2025 оны 03 дугаар сарын 18-нд гэрээ байгуулан 33.248.800.00 /гучин гурван сая хоёр зуун дөчин найман мянга найман зуу/ төгрөгийн компьютер, техник хэрэгсэл нийлүүлсэн. Мөн 2025 оны 08 дугаар сарын 15-нд Голденхоул ХХК-тай гэрээ байгуулан 32.800.000.00 /гучин хоёр сая найман зуун мянган/ төгрөгийн компьютер, техник хэрэгсэл авч, батлагдсан төлөвлөгөөнөөс 25,048,700.00 /хорин таван мянга дөчин найман мянга долоон зуу/ төгрөгийн илүү худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг зарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11" хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан төсвийг хэтрүүлэн илүү худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16

Дугаар 655/А0150053

Улаанбаатар хот

СЭГ-2026/93/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ"-г мөнгөн хөрөнгийн дансны журнал, харилцах дансны хуулгатай тулгахад 71,739,605,000.00 /Далан нэгэн тэрбум долоон зуун гучин есөн сая зургаан зуун таван мянган/ төгрөгийн 1,210 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заалт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдээдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны цахим системд системд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНЖАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар: 656/00150053

Улаанбаатар хот

САГ-2026/53/НА-ЦТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шаардах хуудсаар албан хэрэгцээнд зориулан 2,861,800.00 /хоёр сая найман зуун жаран нэгэн мянга найман зуун/ төгрөгийн кофе, цайг хүргэлтийн үйлчилгээгээр захиалан худалдан авч үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх;" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6.төсвийг зориулалт бусаар зарцуулсан гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Кофе цайг хүргэлтийн үйлчилгээгээр захиалан худалдан авч үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРСҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 657/20150053

Улаанбаатар хот

САТ-2026/93/НА СТА - ТСА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчис ойл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Чингис хаан" Олон Улсын Нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг удирдах хамтарсан компани байгуулах ажлын хэсгийн анхдугаар уулзалтад Велосити инфинит ХХК, Шангрила Улаанбаатар Наадам ресторанд заалны түрээс болон хоолны үйлчилгээний төлбөрт 7,798,180.00 /долоон сая долоон зуун ерэн найман мянга нэг зуун наян/ төгрөг, Гас ХХК-д зочид төлөөлөгчдөд тээврийн хэрэгслийн үйлчилгээнд 440,000.00 /дөрвөн зуун дөчин мянган/ төгрөг, нийт 8,238,180.00 /найман сая хөвөр зуун гучин найман мянга нэг зуун наян/ төгрөг анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэлийн тайлангүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:", 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад зөх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих есоор хөтөлж, баталгаажуулаагүй:" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Ажлын хэсгийн анхдугаар уулзалтад зориулж заалны түрээс болон хоол, тээврийн үйлчилгээний төлбөрийг аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэн үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчис ойл ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дашхүү/, ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Ж.БЯМБАЖАВ